



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

### Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хархорин-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 40,077,224.00 (дөчин сая далан долоон мянга хоёр зуун хорин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Хархорин-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

- 132001375

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн  
6 дугаар тогтоолын хавсралт



**"Хархорин-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

| № | Автомашинны марк,<br>улсын дугаар,<br>зориулалт,<br>хөдөлгүүр, арлын<br>дугаар                                 | Үйлдвэр<br>лэсэн он | Балансын үнэ,<br>Хуримтлагдсан<br>элэгдэл<br>/төгрөг/             | Сэргээн<br>босголтын<br>зардал<br>/төгрөг/ | Худалдах<br>доод үнэ<br>/төгрөг/ |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------|--------------------------------------------|----------------------------------|
| 1 | Тоёото Прадо<br>маркийн 94-23 ӨВР<br>улсын дугаартай,<br>суудлын автомашин,<br>Арлын дугаар<br>RZJ1200023499   | 2003/2012           | 28,239,719.00                                                     | 3,500,000.00                               | 1,000,000.00                     |
| 2 | Хьюндай грейс<br>маркийн 2404ӨВР<br>улсын дугаартай,<br>ачааны автомашин,<br>Арлын дугаар<br>KMEFD37BPXU434022 | 1999/2013           | 11,837,505.00                                                     | 2,000,000.00                               | 500,000.00                       |
|   |                                                                                                                |                     | 40,077,224.00                                                     | 5,500,000.00                               | 1,500,000.00                     |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                                                      |                     | (дөчин сая<br>далан долоон<br>мянга хоёр<br>зуун хорин<br>дөрвөн) | (таван сая<br>таван зуун<br>мянга)         | (нэг сая<br>таван зуун<br>мянга) |